



Интернетэд холбогдохын өмнө

1. Та Zoom-д холбогдоход танд вебкамер, микрофонтой компьютер хэрэгтэй. Хэдийгээр гар утас болон таблетээр холбогдох боломжтой ч **зөөврийн юмуу суурин компьютерээр** оролцох нь илүү дээр шүү.
2. Хурлын явцад илтгэгчийн болон ярьж байгаа хүмүүсийн дуу хоолойг сайн сонсохын тулд чихэвч, микрофонтой **headset** хэрэглэхийг зөвлөж байна.
3. Хурлаас өмнө интернетийн холболтоо шалгаад, сүлжээг бусадтай хуваалцдаг бол хурлын үеэр видео үзэхгүй байхыг анхааруулаарай.
4. Хуралд холбогдохын өмнө <https://www.speedtest.net/> энэхүү линк рүү орж **GO товчийг даран** интернетийн хурдаа шалгаарай. Холболт асуудалгүй сайн ажиллахын тулд энд байгаа PING 50-аас доош, DOWNLOAD 4 буюу түүнээс дээш, UPLOAD 4 буюу түүнээс дээш байх хэрэгтэй.




Хэл сонгох



1. **Interpretation** товчийг дарж боломжтой хэлнүүдийг харна. Монгол орчуулга сонсоё гэвэл “Russian” дарж сонгоно.

Асуулт асуух

1. Танилцуулгууд дууссаны дараа **Асуулт & Хариултын** үеэр асуултаа CHAT-аар бичиж асууна. Хурлын зохион байгуулагч асуултыг уншиж танилцуулна.



Зөвлөмж

- Хуралд орохдоо тухтай газар суугаад камераа цонх юмуу гэрэл харахгүй газар байрлуулах.
- Царайгаа сайн харагдахуйц гэрэлтэй байх
- Камераа хэт дээр биш хэт доор биш нүдтэйгээ нэг түвшинд байхаар тааруулах.
- Хивстэй өрөө цуурайтах нь бага байдаг
- Та хүн багатай өрөөнд байвал харж байгаа хүмүүст төвөг багатай байна.
- Та байгаа тохиолдолд микрофоноо хаах буюу **MUTE** дараарай.
- Боломжтой бол wifi биш сүлжээгээр интернетэд холбогдох нь илүү найдвартай.
- ZOOM-ийн хурлыг илүү чанартай хүлээн авахын тулд бусад ашиглахгүй байгаа аппликейшнүүдаа унтраагаарай

Enjoy your meeting!